



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“1.Барилгын салбарт мөрдөгдөж буй стандарт, норм, дүрмийг шинэчлэх, хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой арга хэмжээний саналыг Хотын стандарт, хяналтын газрын дарга С.Төмөрдулам танилцуулав.

Энэ асуудалтай холбогдуулан:

1.Стандарт, норм, дүрмийг шинээр санаачлах, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналаа бодит судалгаа, тооцоонд үндэслэн боловсруулж, Хотын стандарт, хяналтын газарт 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хүргүүлэхийг нийт нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад;

2.Стандарт, норм, дүрмийг шинээр боловсруулах, шинэчлэх талаарх нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн саналыг нэгтгэн, дүн шинжилгээ хийж холбогдох төрийн захиргааны байгууллагаас тавих шаардлагыг хангасан саналыг Стандарт, хэмжил зүйн газар, Барилгын хөгжлийн төвд 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлэхийг Хотын стандарт, хяналтын газар (С.Төмөрдулам)-т;

3.Стандарт, норм, дүрэмд нийцүүлэн гадна тохижилт, бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар (Б.Мөнхбат)-т;

4.Нийслэлийн хэмжээнд 2020 оноос хойш олгогдсон барилгын ажлын зөвшөөрлүүдийг холбогдох стандарт, норм, дүрэмд нийцсэн эсэх талаар нэгдсэн шалгалт зохион байгуулж үр дүнг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар (Б.Батшагай)-т;

5.Зураг төсөл зохиогчийн хариуцлагыг нэмэгдүүлэх талаар Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлэх арга хэмжээний саналыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор боловсруулж танилцуулахыг Нийслэлийн Ерөнхий архитектор (Н.Нацагдорж)-т тус тус үүрэг болгов” гэжээ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



111020000069